

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын 3.4 дэх заалтын "... Ажлын хэсгийг" гэсний дараа "2-оос доошгүй" гэж нэмсүгэй.

2. Мөн журмын 3.2, 3.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний сонгон шалгаруулалтын талаар 14-өөс доошгүй хоногийн өмнө болон сонгон шалгаруулах үйл явц, шалгарсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ;

"3.3. Иргэн, хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төсөл, хүсэлтийг тухайн төсвийн жилд улирал бүрийн эхний 20 хоногийн дотор (жилд 4 удаа) эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлнэ."

3. Мөн журмын 3.5 дахь заалтын "... хэмжээг хэрэгжүүлэх хүсэлтийг" гэснийг "... хэмжээний нийт төслийг хүсэлтийн хамт" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Эрүүл мэндийн сайд С.ЭНХБОЛД